

**"ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛ"-ИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**  
/2019 оны 3 дугаар улирлын байдлаар/

2019.10.15

Булган аймаг

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2019 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
<b>1. ИРГЭДИЙН ХЭРЭГЦЭЭНД СУУРИЛСАН ҮЙЛЧИЛГЭЭ</b>							
1	1.1. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан иргэн төвтэй "ухаалаг үйлчилгээ" г хөгжүүлэх	1.1.1. Төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг үе шаттай нэвтрүүлж, Төрийн цахим мэдээлэл солилцооны системд төрийн байгууллагуудыг холбох үйл ажиллагааг эрчимжүүлж, цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээний тоог нэмэгдүүлэх;	IV		Төрийн 35 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх	Төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг үе шаттай нэвтрүүлэх ажлын хүрээнд иргэн, хуулийн этгээдээс улсын бүртгэлийн хүсэлт, өргөдөл, баримт бичгийг цахим сүлжээгээр тоон гарын үсгийг үндэслэн хүлээн авах ажлыг эхлүүлэн аймгийн хэмжээнд 16 сум, 1 тосгоны иргэдэд бүртгэлийн үйлчилгээг цахим хэлбэрээр авах нөхцөлийг бүрдүүлсэн. Ингэснээр төрийн үйлчилгээ иргэдэд түргэн шуурхай хүрч байна.	70
2		1.1.3. Орон нутгийн иргэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр авах боломжийг бүрдүүлж, 7 сумыг өндөр хурдны шилэн кабелийн сүлжээнд шинээр холбох;	III		16 сум, 1 тосгонд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр авах боломжийг бүрдүүлэх	Аймгийн 16 сум, 1 тосгон өндөр хурдны шилэн кабелийн сүлжээнд бүрэн холбогдсон. Сумд, байгууллагууд төрийн албан хэрэгцээний цахим программыг бүрэн ашиглаж байна. Улсын бүртгэлийн ерөнхий газар, Азийн хөгжлийн банктэй хамтран хэрэгжүүлж буй "Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор бүртгэлийн системийг боловсронгуй болгох" төслийн хүрээнд бүх сумд нэгдсэн сүлжээнд холбогдсон.	100
3		1.1.4. Төрийн үйлчилгээний "Цахим үйлчилгээний төв"-ийг орон нутагт байгуулах;	IV		16 сум, 1 тосгонд цахим үйлчилгээний төв-ийг байгуулна	Төрийн үйлчилгээний нэгдсэн "Цахим төв"-ийг байгуулах саналыг боловсруулан ЗГХЭГ-т хүргүүлсэн.	30
4	5	1.2.1. Төрийн үйлчилгээний албан ёсны жагсаалтыг гарган, төрийн үйлчилгээний стандартыг боловсруулах;	IV		Төрийн 320 үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлнэ	Цахим сүлжээгээр тоон гарын үсгийг үндэслэн хүлээн авах ажлыг эхлүүлэн аймгийн хэмжээнд 16 сум, 1 тосгоны иргэдэд бүртгэлийн үйлчилгээг цахим хэлбэрээр авах нөхцөлийг бүрдүүлсэн. Ингэснээр төрийн үйлчилгээ иргэдэд түргэн шуурхай хүрч байна.	70
		1.2.2. Төрөөс үзүүлдэг үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээний байгууллага бүр тоо хэмжээ, цаг хугацаа, чанар, өртөг гэсэн үзүүлэлтээр үйлчилгээний стандарт тогтоож хэрэгжүүлэх;	IV		Төрийн 176 үйлчилгээг "ХУР" системд холбож төрийн үйлчилгээний чанар сайжруулна	Аймгийн хэмжээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Татварын хэлтэс зэрэг байгууллагууд "ХУР" системд холбогдож, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үзүүлж байна.	70

6	1.2. Иргэдийн хэрэгцээнд суурилсан төрийн үйлчилгээний стандартын тогтолцоог хөгжүүлэх	1.2.3. Анги дүүргэлт хэт өндөртэй сургууль, цэцэрлэгийн ачааллыг бууруулж, 3 ээлжтэй сургуулийг 2 ээлжинд шилжүүлэх;	III		Аймгийн хэмжээний бүх сургууль 2 ээлжинд шилжинэ	Аймгийн хэмжээнд Хутаг-Өндөр сумын сургуулийн 1 дүгээр ангийн 3 бүлэг 3 ээлжээр хичээллэж байна. Тус сумын сургуулийн барилгын хүчин чадлыг нэмэгдүүлэхээр 2019 оны улсын төсвөөс Хутаг-Өндөр сумын сургуулийн өргөтгөлийн барилгад 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдэж, Улаанбаатар хотын "Алтайн Бумбат өргөө" ХХК-тай гэрээ байгуулан барилгын ажлыг гүйцэтгүүлж байна.	30
7		1.2.4. Сурагчид дотуур байрандаа эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг сайжруулж, бага ангийн 6-8 настай хүүхдэд зориулсан асаргаа, халамж, хөгжлийн үйлчилгээ бий болгох;	IV		Рашаант, Бүрэгхангай сумдын ЕБС-ын дотуур байрны стандартыг хангуулна	Аймгийн хэмжээнд 26 дотуур байр 1921 хүүхэд амьдарч байна. Хүүхдийн аюулгүй байдлыг хангах, эрүүл орчин бүрдүүлэх, олон нийт, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор дотуур байрны үйлчилгээг сайжруулан гэрийн нөхцөлд ойртуулан тохижуулах ажлыг Бүрэгхангай, Орхон, Тэшиг, Хишиг-Өндөр сумын сургуулиуд эрчимтэй өрнүүлж, сургууль бүр 6-14 тасгийг 1.0-1.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тохижуулсан. Мөн "Хүүхэд хамгааллын жишиг бодлого"-ыг эрчимжүүлэх зорилгоор 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн анги удирдсан багш, дотуур байрны багш, эцэг эх, суралцагчийн дөрвөлсөн гэрээг байгуулан ажиллаж байна.	70
8		1.2.5. Ахлах сургуулийн сурагчид сургуулиа төгсөөд сурах их дээд сургууль, мэргэжлээ зөв сонгох, элсэн суралцах бэлтгэлийг хангах талаар ажил мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг эхлүүлэх;	IV		10-12 дугаар ангийн 1466 суралцагчийг ажил мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээнд хамруулна	Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төслийн хүрээнд эцэг эх, багш, сурагчид, сургуулийн удирдлагуудад гарын авлага тараасан. Монголын залуучуудын холбоо, их дээд сургуулиудын холбоотой хамтран аймгийн хэмжээний ахлах ангийн сурагчдад мэргэжлээ зөв сонгох, элсэн суралцах бэлтгэлийг хангах талаар ажил мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээг 3-5 удаа өгч 1162 сурагчийг хамруулсан.	100
9	1.3. Иргэн төвтэй төрийн үйлчилгээний менежментийг сайжруулах хөтөлбөрийг салбар бүр хэрэгжүүлэх	1.3.1. Байгууллага бүр үйлчилгээний менежментийг сайжруулах чиглэлээр хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;	I y		Байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмж сайжруулах төлөвлөгөө боловсруулсан байна	Аймгийн хэмжээнд 16 сум, 1 тосгоны Засаг даргын Тамгын газар болон төр, төсвийн байгууллагуудын төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, төрийн үйлчилгээг иргэдэд хурдан шуурхай хүргэх зорилгоор "Угтах үйлчилгээ"-г нэвтрүүлсэн. Аймгийн хэмжээнд 11 сум, 13 байгууллага "Хүлээж суулгүй, хүрч үйлчилье" нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж, төрийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэсэн.	100
10		1.3.2. Үйлчлүүлэгчтэй харилцах нэгжийг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан бэхжүүлж, үйлчилгээний ажилтан, менежерийг чадавхжуулах, холбогдох сургалтад хамруулах;	IV		Хэрэгжилтийг хангаж ажиллах	2019 оны эхний хагас жилийн байдлаар 16 сум, 1 тосгон, 22 агентлаг, төр төсвийн байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч нарт ажлын байрны шинжилгээ хийх, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, төрийн албан хаагчийн ёс зүйн талаарх сургалтыг Төрийн албаны зөвлөл, "Удирдлагын академи"-тай хамран 3 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 680 албан хаагчийг хамрууллаа. 8, 9 дүгээр сард "Удирдлагын академи"-тай хамтран сумд, байгууллагуудын албан хаагчдад нэгдсэн сургалт зохион байгуулж, 120 гаруй албан хаагчдыг хамруулсан.	70

11		1.4.1. Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үйлчилгээний стандартыг боловсронгуй болгох;	IV		Үйлчилгээний стандартыг мөрдүүлэх	Хүн амын зорилтот бүлгийн иргэдийг нийгмийн харилцаанд тэгш оролцох нөхцөл боломжийг хангах, тэдэнд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. 2019 онд Төрийн банк, Хаан банк, Хас банк, Мобиком, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Булган-Мээж ТӨХК зэрэг байгууллагууд тусгай хэрэгцээт иргэдийн тэмдэглэгээ бүхий машины зогсоол, үйлчилгээний зааланд дугаар авалгүй үйлчлүүлэх боломжоор ханган ажиллаж байна. Мөн ерөнхий боловсролын 3 дугаар сургууль, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь тусгай тоноглол бүхий тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан бие засах газрыг тохижуулан үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлсэн.	100
12	1.4. Зорилтот бүлэгт чиглэсэн төрийн үйлчилгээг хөгжүүлэх	1.4.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн анхдагч мэдээллийн сан байгуулах	IV		Мэдээллийн санг жил бүр шинэчлэн бүрдүүлсэн байна	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим мэдээллийн санг улирал тутам шинэчлэн баяжуулж үйл ажиллагаанд ашиглаж байна. 3 дугаар улирлын байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 2328 иргэн бүртгэлтэй байгаа буюу нийт хүн амын 3.5 хувийг эзэлж байна. Тус иргэд нь нийгмийн даатгалын сан, нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр тэтгэмжээ авч байгаа бөгөөд халамжийн сангаас 646 буюу 27%, нийгмийн даатгалын сангаас 1682 иргэн буюу 72% нь тус тус үйлчилгээ авч байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг өвчлөлөөр авч үзвэл сэтгэц 442 буюу 21.6%, дотор 336 буюу 17.9%, нүд 343 буюу 16.7%, мэдрэл 272 буюу 13.3%, гэмтлийн өвчин 259 буюу 12.7%-ийг эзэлж байна. Сумдаар авч үзвэл Булган, Хутаг-Өндөр, Тэшиг, Сайхан сумдууд давамгайлж байна. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувиар авч үзэхэд 70 буюу түүнээс хувиар хөдөлмөрийн чадвараа алдсан иргэн 48.6 хувь, 50-69 хувиар алдсан иргэд 51.4 хувийг эзэлж байна. Насны ангиллаар авч үзэхэд 20-50 насны иргэд зонхилж байна. 2019 оны 3 дугаар улирлын байдлаар нийгмийн халамжийн сангаас 184 хөгжлийн бэрхшээлтэй иргэн протез, ортопедийн хөнгөлөлт эдэлж, 60.2 сая төгрөгийн дэмжлэг авсан байна.	100
13		1.4.5. Зорилтот бүлгийн хөгжил, амьжиргааны түвшний талаар цахим мэдээллийн сан бий болгож, тэдгээрийн хэрэгцээ, үр чадварт нийцүүлэн нийгмийн халамжийн дэмжлэг, үйлчилгээг үзүүлэх;	IV	Аймгийн төсөв 17.0 сая төгрөг	Зорилтот өрхийн хөгжлийг хамгаалах дэд хөтөлбөрийн хүрээнд 351 өрхөд нийгмийн халамжийн дэмжлэг үзүүлнэ	Зорилтот өрхийн 351 гишүүдээс санал авч, иргэн бүртэй хамтран ажилласан нь тэдний идэвх санаачлага, үр чадварт нь тулгуурлан хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан, аж байдлын дэлгэрэнгүй судалгааг гаргахад үр дүнтэй ажил болов. Байнгын ажлын байранд зуучилсан 38, түр ажлын байранд 67, нийтийг хамарсан ажилд 89, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөлд 23 иргэн хамрагдсан байна. Өрхийг ажилд зуучлах, төсөл хөтөлбөрт хамруулах, дэмжлэг туслалцаа үзүүлэх, өрх хэрхэн өөрчлөгдөж байгаад хяналт тавихад амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүд, төрийн болон төрийн бус байгууллагуудыг хуваарилан ажилласан. Гэр бүлийн гишүүдийн насны онцлогт тохирсон спорт, урлаг, соёлын, бүлгийн зохион байгуулалттай сургалт, хөдөлмөр эрхлэх сургалт, иргэдийн зан үйлийг өөрчлөхөд чиглэсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсний үр дүнд 305 өрх буюу 87% нь амьжиргаа сайжирсан гэсэн үзүүлэлт гарсан.	100
14	1.6. Төрийн үйлчилгээг удирдах, хянах иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	1.6.1. Нийгмийн суурь үйлчилгээ үзүүлдэг төрийн зарим байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог бий болгох;	IV		Аймаг, сумдын иргэний танхимаар дамжуулан иргэний оролцоог хангана	2019 оны 3 дугаар улирлын байдлаар аймгийн хэмжээнд 124 хэлэлцүүлэг, 216 сургалт зохион байгуулж нийт 20084 иргэнийг хамруулан иргэдийн санал бодлыг бодлого шийдвэрт тусгуулах ажлыг зохион байгуулж байна.	100

2. ИЛ ТОД БАЙДАЛ, ИРГЭНИЙ ОРОЛЦООТОЙ ШИЙДВЭР ГАРГАЛТ

15	2.1. Шийдвэр гаргах үйл явцыг ил тод болгож, иргэдийн оролцоог хангах	2.1.1. Бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангаж, мэдээлэл ил тод, нээлттэй, хүртээмжтэй байх нөхцөлийг бүрдүүлэх;	IV		Цахимаар авах ажиллагааг эхлүүлнэ санал үйл	Аймгийн албан ёсны цахим хуудасны баяжилт шинэчлэлтийг тухай бүр хийж, 2019 оны 3 дугаар улирлын байдлаар цаг үеийн мэдээ болон фото 135 мэдээ, видео 25 мэдээ бэлтгэн байршуулав. Сум, агентлагуудаас ирсэн онцлох мэдээ, цаг үетэй холбоотой зөвлөмж, үйл ажиллагааны тайланг www.bulgan.gov.mn хуудсаар дамжуулан иргэдэд мэдээлж байна. Бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, мэдээллийг ил тод, нээлттэй, хүртээмжийг нэмэгдүүлэхээр “Сайхан Монгол” орон нутгийн телевизтэй хамтран “Иргэдээ сонсьё” шууд нэвтрүүлгийг Пүрэв гараг бүр 19.00 цагаас шууд нэвтрүүлж хэвшлээ.70347034 дугаарын нээлттэй утсанд тайлант хугацаанд 118 санал хүсэлт ирүүлснийг шууд шийдвэрлэх боломжтойг газар дээр нь хариуг хүргүүлж, удаан хугацаанд шийдвэрлэгдэх асуудлаар гаргасан өргөдлийг бүртгэн шийдвэрлүүлж байгаа нь үр дүнтэй ажил болж, ил тод байдлыг хангахад түлхэц болж байна.	100
16		2.1.2. Зөвлөлдөх ардчиллын санал асуулгыг нэвтрүүлэн иргэдийг тэнцвэртэй, үнэн зөв мэдээллээр ханган, шийдвэр гаргах түвшний иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;	IV		Хэрэгжилтийг хангаж ажиллах	Нутгийн захиргааны байгууллагуудаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээний талаар иргэдэд лавлагаа, мэдээлэл өгөх, санал асуулга, судалгаа явуулах, иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, аймаг, орон нутгийг хөгжүүлэх чиглэлээр гарч байгаа шийдвэрт иргэдийнхээ санал бодлыг тусгах, төр иргэндээ шуурхай үйлчлэх зорилт тавин ажиллаж байна. Иргэдээс 2019 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 8103 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирүүлснээс АЗДТГ-т 710 иргэн хандаж өргөдөл гомдол гаргасан нь 0.8 хувь, харьяа агентлагт 40.8 хувь буюу 3309, сумдын ЗДТГ-т 4084 иргэн хандаж өргөдөл гомдол гаргасан нь 50.4 хувийг эзэлж байна. Иргэний танхимаар энэ улиралд 124 хэлэлцүүлэг, 216 сургалт зохион байгуулж нийт 20084 иргэд оролцсон байна.	100
17	2.2. Төсөв, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх	2.2.1. Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь тогтмол мэдээлэх, хяналт, хариуцлагыг сайжруулах;	IV		Зөрчил, дутагдлыг багасгаж, гүйцэтгэлийг 99%-д хүргэнэ	Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба нь Монгол улсын Шилэн дансны тухай хуулийн 8.2. “Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ.”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам” –ын хүрээнд 2019 оны 06 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон, дүнг нэгтгэн тайлагнаж байна. Үүнд 119 байгууллага 1337 мэдээллийг хоцроож мэдээлсэн.	100
18		2.3.1. Төрийн үйлчилгээг иргэнд хүргэх чиг үүрэг бүхий байгууллага өөрийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа дүрэм, журам, үйлчилгээний ажилтны чиг үүрэг, эрх хэмжээ, үйлчилгээ үзүүлэх хугацаа, бүрдүүлэх шаардлагатай материал зэрэг мэдээллийг нээлттэй хүргэж байх;	IV		Үзүүлэлтийг 96%-д хүргэнэ	Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/34 тоот тушаалаар батлагдсан аймгийн Засаг даргын Тамгын газрын нээлттэй утас, саналын хайрцаг ажиллуулах журмыг батлуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Мөн төрийн үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан ажилтны ажиллах цагийн хуваарь, холбогдох шууд утас, цахим шууданг аймгийн албан ёсны вэб хуудас, олон нийтийн сүлжээ, мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулж байна.	100

19	2.3. Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлэх	2.3.2. Иргэн, хуулийн этгээдэд хэрэгцээтэй, тэдэнд хамаарах шийдвэрийг цахим хуудас болон бусад хэлбэрээр нийтэд мэдээлж хэвших;	IV		Цахим хуудсанд мэдээлэх ажлыг 30 хувиар нэмэгдүүлж, сумд, байгууллагууд нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулна	Төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж болон шинээр мөрдөгдөж байгаа хуулиудыг онцлон 16 сум, 1 тосгон, төрийн байгууллагуудын цахим хуудсаар дамжуулан шторк 9, слайд 20, сургалт, сурталчилгааны богино хэмжээний 29 төрлийн киног эрх зүйн мэдлэг, мэдээлэл олгох цахим мэдээллийн сан бүхий "э-хөтөч" портал сайтад 16 сум, 1 тосгоны мэдээллийг байршуулан мэдээлж байна. Аймгийн гэр бүлийн 106.5 FM радиотой хамтран ажиллаж 7 хоногийн 2 өдөр "Хуулийн цаг" шууд нэвтрүүлгийг явуулж хэвшээд байна.	100
20		2.3.3. Иргэнээс гарах үйл ажиллагааны зардал, төрийн үйлчилгээ авах цаг хугацааг бууруулах зорилгоор шат дамжлагыг цөөлөх, үйл ажиллагааг оновчтой болгоход чиглэсэн дүрэм, журмыг хянан үзэж өөрчлөх, хүчингүй болгох арга хэмжээ авах;	II		Дүрэм, журмын холбогдох заалтыг оновчтой болгоно	Аймгийн ИТХ, Тэргүүлэгчид, аймгийн Засаг даргаас 2012-2018 онд гаргасан шийдвэрүүдэд судалгаа хийж 123 шийдвэрт өөрчлөлт оруулах саналыг боловсруулан. Хуулиар олгосон эрх хэмжээ нь хэтэрсэн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан 12 шийдвэрийг хүчингүй болгож, холбогдох хуулиудад нийцүүлэн батлуулах талаар холбогдох хэлтсүүдэд зөвлөмж, чиглэлийг өгч хэрэгжилтийг хангасан.	100
21		2.3.4. Байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаа нь тухайн байгууллагын ажилтнуудад нээлттэй байх, шийдвэрийн үндэслэлийн талаарх мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд нээлттэй болгох.	IV		Хүний нөөцийн ил тод байдлын шалгуур үзүүлэлт 94%-тай	Монгол улсын Засгийн газрын 2007 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан Ил тод байдлыг илтгэх шалгуурын хэрэгжилтэд хяналт шалгалт хийлээ. Хяналт шалгалтын дүнгээр Төрийн байгууллагуудын хүний нөөцийн ил тод байдлыг сайжруулах шаардлагатай гэж дүгнэсэн. Төрийн байгууллагууд удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагааг албан хаагчдад нээлттэй болгох зорилгоор хамт олны хурлыг хагас жил тутам зохион байгуулж, үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны мэдээ, тайланг ил тод нээлттэй танилцуулах ажлыг хэвшүүлж байна. Байгууллага бүр цахим хуудаст тушаал шийдвэрийг ил тод нээлттэй байршуулдаг. Хүний нөөцийн ил тод байдлын шалгуур үзүүлэлт 2019 оны 3 дугаар улирлын байдлаар 87 хувьтай байна.	70
22	2.4. Мэдээлэл хүргэх оновчтой тогтолцоог бий болгох	2.4.2. Төрийн байгууллагуудаас иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх мэдээллийн системд танилт нэвтрэлтийн нэгдсэн ДАН системийг холбох;	II		Цахим хэлбэрээр үзүүлэх Төрийн үйлчилгээг нэмэгдүүлнэ	Улсын бүртгэлийн хэлтэс нь BURTGEL.MN сайтаар иргэн болон хуулийн этгээдийн үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд эдгээр үйлчилгээг үзүүлэхийн тулд танилт нэвтрэлтийн нэгдсэн ДАН системд холбогдон үйлчилгээ үзүүлж байна.	100
3. ОНОВЧТОЙ ЧИГ ҮҮРЭГ							

23	3.2. Чиг үүргийн дахин хуваарилалтыг хийж, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох	3.2.1. Төвлөрлийг сааруулах, төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор төрийн захиргааны болон нутгийн удирдлагын байгууллагын чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийж, чиг үүргийг дахин хуваарилах;	IV		Төрийн байгууллагын чиг үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхой болгоно	Аймгийн хэмжээнд 148 төрийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлэх, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулах ажлын хүрээнд ажлын байрны шинжилгээг хийгээд байна. Ажлын байрны шинжилгээний дүнд үндэслэн Эрхэлсэн түшмэлийн ангиллын 2, Ахлах түшмэлийн ангиллын 13 албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлөөр хянуулан баталгаажуулаад байна. Мөн төрийн үйлчилгээний 3027 албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг эрх бүхий албан тушаалтан хянан баталгаажуулах ажлыг зохион байгууллаа.	100
24		3.2.2. Орон нутгийн хөгжлийн загварт тулгуурлан нийгмийн үйлчилгээний жишиг нормативыг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг жигд хүртээмжтэй болгох.	IV		Хэрэгжилтийг хангаж ажиллах	Засгийн газрын 2010 оны 334 дүгээр тогтоолоор батлагдсан "Нийгмийн үйлчилгээний жишиг норматив"-ыг хэрэгжүүлэн иргэдийн ая тухтай амьдрах таатай орчинг бүрдүүлэх, нийгмийн үйлчилгээг иргэдэд тэгш, чанартай, үр ашигтай хүртээх замаар төрөөс авч байгаа үйлчилгээнд сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхийг зорин ажиллаж ирлээ. Аймгийн хэмжээнд 11 сум, 13 агентлаг иргэдэд "Нэг цэг"-ийн үйлчилгээ үзүүлж байна.	70
<b>4. ҮР ДҮНД СУУРИЛСАН УДИРДЛАГА</b>							
25	4.1. Гүйцэтгэлийн үнэлгээгээр хувь хүний өрсөлдөх чадварыг хөхиүлэн дэмжих	4.1.1. Үр дүнд суурилсан удирдлагын хяналт, шинжилгээ, үнэлгээний системийг нэвтрүүлэх;	IV		Бодлого төлөвлөлт, төсөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөө нэмэгдсэн байна	Бодлогын баримт бичиг, хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сум, байгууллагуудаас ABLE программаар авч хэвшсэн. Ингэснээр мэдээ, тайлангууд цаг алдалгүй хугацаандаа ирж, түүний мөрөөр засаж сайжруулах зөвлөмжийг нэгж байгууллагад хүргүүлэн цаашдын үйл ажиллагаандаа тусгаж ажиллах нөхцөл бүрдсэн.	100
26	4.2. Гүйцэтгэлийн үнэлгээг сайжруулж, олон тулгуурт хяналтын тогтолцоог хөгжүүлэх	4.2.1. Төрийн байгууллагын үйл ажиллагааг бус үр дүнг үнэлдэг үнэлгээний тогтолцоог хөгжүүлэх; (иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг нэвтрүүлж төрийн бодлогын үр дүн, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг хараат бусаар үнэлж, дүгнэн зөвлөмжийн дагуу хариу арга хэмжээ авч ажиллах соёлыг хэвшүүлэх)	IV	Засаг даргын нөөцийн хөрөнгө 7.7 сая	Хэрэгжилтийг хангаж ажиллах	Хэрэглэгчийн үнэлгээний судалгааг энэ жилээс эхлэн ЗГХЭГ-аас нэгдсэн байдлаар зохион байгуулахаар болсон.	100

27		4.2.2. Иргэдийн сэтгэл ханамжийн үндэсний индекс тэй болох;	III		Иргэдийн сэтгэл ханамжийг 60%-д хүргэнэ	Хэрэгжээгүй.	0
28		4.2.3. Төрийн үйлчилгээнд иргэдийн үнэлгээний картын системийг нэвтрүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх.	IV		Хуулийн төсөлд саналаа хүргүүлнэ	Хэрэгжээгүй.	0
5. ИРГЭН ТӨВТЭЙ МЭРГЭШСЭН ТӨРИЙН АЛБА							
29	5.1. Төрийн албаны хүний нөөцийн төлөвлөлтийг хөгжүүлж, сургалт хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх	5.1.1. Иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилгох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулахдаа хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах зарчмыг тууштай хэрэгжүүлэх;	IV		Төрийн албаны тухай хуулийн "Чадахуйн зарчим"-ыг хэрэгжүүлнэ	Төрийн албанд иргэнийг сонгон шалгаруулах, шатлан дэвшүүлэх ажлын бэлтгэл ажлыг ханган, төрийн албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж байна. Аймгийн хэмжээнд 512 төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтын төслийг боловсруулан Эрхэлсэн түшмэлийн ангиллын 2, Ахлах түшмэлийн ангиллын 13 албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлөөр хянуулан баталгаажуулаад байна. Дэс, туслах түшмэлийн ангиллын албан тушаалын тодорхойлолтын төслийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөр хянуулахаар бэлтгэл ажлыг хангаад байна. Төрийн албаны ерөнхий шалгалтыг зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган, шаардлагатай тоног төхөөрөмж, хүн хүчний судалгааг гарган Төрийн албаны зөвлөлд хүргүүлээ. Албан тушаалын тодорхойлолт баталгаажсаны дараа шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах нөхцөл бүрдэнэ.	70
30		5.1.3. Төрийн албан хаагч тогтвортой ажиллах, төрийн алба хаших шалгуур нь зөвхөн мэргэшлийн болон уг албыг гүйцэтгэх мэдлэг чадвар, мэргэжлийн ёс зүйгээр тодорхойлогддог байх нөхцөлийг бүрэн хангах;	IV		Мэргэшсэн албан хаагчдын тоо 50-аас доошгүй хувьд хүргэнэ	Монгол улсын Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан жилийн эцэст ажлын гүйцэтгэл, мэргэшлийн түвшин, мэдлэг хандлагыг үнэлэхээр бэлтгэж байна. Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг баримтлан төрийн байгууллагууд "Ёс зүйн зөвлөл"-ийг шинэчлэн ажиллаж байна. "Төрийн албан хаагчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний тухай" илтгэлийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлсэн.	70
31	5.2. Цалин хөлс, урамшуулал, нийгмийн баталгаа	5.2.4. Төрийн албан хаагчийн орон сууцны хөтөлбөрийг баталж, орон сууцаар хангагдах нөхцөлийг бүрдүүлэх;	II		Төрийн албан хаагчдын орон сууцны нөхцөлийг сайжруулна	Төрийн албан хаагчийн хүний нөөцийн системийн тайланд үндэслэн Булган аймгийн төрийн албан хаагчдын орон сууцны судалгаагаар төрийн албан хаагчдын 21.9 хувь нь орон сууцанд, 66.2 хувь нь хашаа байшинд, 2.4 хувь нь гэрт, 5.1 хувь нь түрээсийн орон сууцанд, 4.1 хувь нь бусдын орон сууцанд амьдарч байна. Булган сумын 6 дугаар багт төрийн албан хаагчдад зориулсан 320 айлын орон сууц барих зориулалттай газрыг аймгийн Засаг даргын Тамгын газрын мэдэлд шилжүүлсэн. Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний зураг төслийг боловсруулж байна.	70

32	5.3. Ажлын байрны шинжилгээ, үнэлгээ	5.3.1. Ажлын байрны шинжилгээг хийж, тухайн ажлын байранд тавигдах шалгуурыг тодорхой тогтоох, ажил үүргийн давхардал, хийдлийг арилгах, цалин хөлсний системийг боловсронгуй болгох, ажилтнуудын сургалтын хэрэгцээг тодорхойлох, ажилтнуудын ачааллыг тэнцвэржүүлэх арга хэмжээ авах.	II		3872 албан хаагчийн ажлын байрны шинжилгээ хийгдэж, ачааллыг тэнцвэржүүлэн, ажлын үр нөлөөг нэмэгдүүлнэ	Төрийн байгууллага бүр ажлын байрны шинжилгээ хийж, албан тушаалын тодорхойлолтыг шинэчилсэн. Аймгийн хэмжээнд 512 төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтын төслийг боловсруулан Эрхэлсэн түшмэлийн ангиллын 2, Ахлах түшмэлийн ангиллын 13 албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлөөр хянуулан баталгаажуулаад байна. Дэс, туслах түшмэлийн ангиллын албан тушаалын тодорхойлолтын төслийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөр хянуулахаар бэлтгэл ажлыг хангаад байна. “Төрийн албаны тухай” хууль шинэчлэн найруулагдаж 2019 оноос хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Удирдлагын академийн төлөвлөгөөт Эрхэлсэн түшмэлийн ангиллын мэргэшүүлэх сургалтад 2, богино хугацааны сургалтад 42 албан хаагч хамрагдаад байна.	70
Нэгдсэн дүн						79.1	